



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Л.Равдандорж Утас: 70523020 Цахим хаяг: ravdandorjl@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Додд. од. дд № *1-6/69*
танай _____ -ны № _____ -т

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА,
ЦАГДААГИЙН ХОШУУЧ Б.ДАВААХҮҮ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	451.5	422.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,386.1	283.6
	Нийт хөрөнгийн дүн	3,837.6	3,744.7
	Нийт өр төлбөрийн дүн	0.0	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,837.6	3,744.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,837.6	3,744.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	2,427.8	2,714.0
	Үйл ажиллагааны зардлын дүн	2,563.7	2,725.9
	Үйл ажиллагааны үр дүн	-135.9	-11.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-18.6	-67.1
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-154.5	-79.0
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,992.1	3,858.5
	Тайлант оны үр дүн	-154.5	-79.0
	Эцсийн үлдэгдэл	3,837.6	3,744.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	2,198.8	2,357.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	2,188.8	2,338.3
	Үйл ажиллагааны ЦМГ	9.9	19.1
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-9.9	-19.1
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,145.5	2,259.0
	Урсгал зардал	2,145.5	2,259.0
	Хөрөнгийн зардал		
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
	Улсын төсвөөс санхүүжих	2,078.4	2,194.4
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	67.1	80.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын зорилго: Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлж, ил тод, шударга, шуурхай, хуульч, ажиллагааг хэвшүүлнэ.

Дорноговь аймгийн Цагдаагийн газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

1. Гэмт хэрэгтэй тэмцэх.
2. Нийтийн хэв журам хамгаалах.
3. Олон нийтийн аюулгүй байдлыг хангах.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь ахмадын сангийн үйл ажиллагааг хаан банканд нээсэн төрийн бус байгууллагын дансаар дамжуулан хэрэгжүүлдэг. Тайланд онд тус дансанд төсвөөс мөнгө шилжүүлээгүй байна.

Гэвч Цагдаагийн ерөнхий газрын санхүү, аж ахуйн албанаас 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 6/1865 тоот албан бичгээр байгууллагын хэмнэгдэж байгаа зардлыг ЦЕГ-ын ахмадын сангийн дансанд төвлөрүүлэх тухай чиглэл ирүүлсэн.

Дорноговь аймгийн Цагдаагийн газраас батлагдсан төсвийн хэмнэлт болох нийт 4.6 сая төгрөгийг ЦЕГ-ын ахмадын сангийн 100900012545 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татах асуудал илрээгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ахмадын сангийн санхүүжилт, зарцуулалтыг авч үзэх.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 840.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 836.0 сая төгрөгийн алдааг залруулж, 4.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

7.1 Залруулсан алдаа

1. Үнэ төлбөргүй бэлтгэсэн 30.0 сая төгрөгийн хөрөнгийг үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн.

2. Үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд цалин, хөлс нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ зардлын дүнг алдаатай илэрхийлсэн.

7.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Батлагдсан төсвийн хэмнэлт нийт 4.6 сая төгрөгийг ахмадын санд төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйл 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.7-д “Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр “Ахмадын сан” байгуулах бөгөөд Ахмадын сан байгуулан ажиллуулах журмыг Засгийн газар батална”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар

тогтоолын 2-р хавсралт “Ахмадын сан байгуулах журам”-ын 1.3-т “Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана” гэж заасныг тус тус зөрчсөн байна

- 1.2. Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж, төсвийн хэмнэлийг ахмадын санд төвлөрүүлэхгүй байх.

2. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, татварын суутгалыг зөрүүтэй тусгаж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

- 2.2. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журам, заавар, стандартын дагуу хөтөлж тайлан мэдээг гаргаж байх.

2.3.

8.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

8.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	Дорноговь аймгийн Цагдаагийн газар	4	840.7	2	836.0	-	-	-	-	2	4.7
	НИЙТ	4	840.7	2	836.0			-	-	2	4.7